



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 17 оны 5 дугаар
сарын 16 -ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7, 19 дүгээр зүйлийн 19.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг угсрах, ашиглах, засвар үйлчилгээ хийх заавар"-ыг нэгдүгээр, "Гал түймрийн аюулын үнэлгээ хийх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар /бригадын генерал Т.Бадрал/-т даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 5
дугаар сарын 6 -ны өдрийн 49 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**ГАЛ ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ТЕХНИК, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛ УГСРАХ, АШИГЛАХ,
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн техникийн үйлчилгээ, угсрах, ашиглах болон засвар үйлчилгээ (цаашид “ГТХТТ-ийн техникийн үйлчилгээ” гэх) эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг өмчийн төрөл харгалзахгүй ГТХТТ-ийн техникийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3. Галын аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох стандарт, дүрэм, журмаар тогтоосон шаардлагыг бүрэн хангаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага “ГТХТТ-ийн техникийн үйлчилгээ” эрхэлж болно.

1.4. ГТХТТ-ийн техникийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхдээ холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт болон оюуны өмчийн харилцааны тухай болон патенттай холбоотой Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрийг мөрдөн ажиллана.

1.5. ГТХТТ-ийн техникийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхдээ тусгай зөвшөөрөл авсан, эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаар тогтоолгосон байна. Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 5 дугаар сарын 07-ны 89 дүгээр тушаалаар баталсан “Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын нэгдүгээр хавсралтын 2.2.2-т “Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт”-ын чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлнэ.

1.6. ГТХТТ-ийн техникийн үйлчилгээ эрхлэх байгууллага нь тухайн үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэх талаар эрх бүхий байгууллагаас баталсан хугацааны тохирлын баталгаанд хамрагдсан байна.

1.7. ГТХТТ-ийн техникийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах этгээдэд тавих шаардлагыг БНБД-ээр (үндэсний стандартаар) тогтооно.

1.8. ГТХТТ-ийн техникийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

1.8.1. техникийн үйлчилгээ, засвар

1.8.2. ашиглалтын материалаар хангах

1.8.3. тоног төхөөрөмжийн угсралт

1.9. ГТХТТ-ийн техникийн үйлчилгээ эрхлэх байгууллагын ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулахгүй байх, үйл ажиллагаандаа заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байна.

1.10. ГТХТТ-ийн техникийн үйлчилгээ эрхлэх байгууллага нь орон нутгийн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан тухайн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тавигдаж буй нийтлэг шаардлагыг мөрдөж ажиллана.

1.11. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл болон бүтээгдэхүүнтэй холбоотой зохиогчийн эрх, патент, лиценз, гэрчилгээ эзэмшигчийн зохих зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэгчийн болон бүтээгдэхүүний нэрийг үйлчилгээндээ ашиглахыг хориглоно.

Хоёр. Техникийн болон засвар үйлчилгээ

2.1. Техникийн болон засварын үйлчилгээнд гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаанд техникийн бүрэн байдал, найдварт ажиллагааг хангахад чиглэгдсэн бүх төрлийн техникийн үйлчилгээ, засвар зэрэг үйлчилгээ хамаарна.

2.2. Техникийн болон засварын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь тухайн салбарын мэргэжлийн байгууллага байх бөгөөд инженер техникийн ажилчид нь тухайн ажил, үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн үнэмлэх, зэрэгтэй байна.

2.3. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжид техникийн үйлчилгээ, засвар хийхдээ үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэм, зааварчилгааг мөрдлөг болгон ашиглах бөгөөд технологийн карт, аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулж мөрдөн ажиллана.

2.4. Техникийн болон засварын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үйлчилгээ, засварын ажилдаа техникийн үзүүлэлт, галын аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгөх ба баталгааг дагалдах хуудсаар баримтжуулна.

2.5. Баталгаат хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаанаас доошгүй байх бөгөөд хэрэв үйлдвэрлэгчээс хугацаа тогтоогоогүй бол баталгаат хугацаа нь 1 жилээс доошгүй байна.

2.6. Техникийн үйлчилгээ, засварын байгууллагын, эрх, үүрэг

2.6.1. техникийн үйлчилгээ, засварын үнэ тарифыг тогтоох;

2.6.2. аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулан мөрдүүлэх;

2.6.3. үйлчилгээндээ баталгаат хугацаа тогтоох;

2.6.4. үйлчилгээ үзүүлэхдээ гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тухай бүртгэл хөтлөх ба хүлээн авсан гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцна;

2.6.5. засвар үйлчилгээний мэдээллийг тухай бүрт нь мэдээллийн санд тэмдэглэнэ;

2.6.6. баталгаат хугацаанд техникийн үйлчилгээ, засварыг хэрэглэгчид үзүүлэх;

2.6.7. үйлчилгээндээ үндэслэлтэй тогтоосон үнэ тарифыг мөрдөх;

2.6.8. үйлчилгээ, засвар хийсэн гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг үйлчлүүлэгчид техникийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагаатай эсэхийг нь шалгаж хүлээлгэн өгөх;

2.6.9. өөрийн үйлчилгээний төвийн байршил, цагийн хуваарь зэрэг мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

2.6.10. засвар үйлчилгээ хийлгэх захиалгыг цахим сүлжээгээр хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх.

2.6.11. засвар үйлчилгээний график төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон төлөвлөгөөт бус засвар, гэмтлийн дуудлагын дагуу засвар үйлчилгээг гүйцэтгэх

2.7. Техникийн болон засварын үйлчилгээ эрхлэх байгууллагад хориглох зүйл

2.7.1. гарал үүслийн гэрчилгээгүй, үйлдвэрлэгчээс тогтоосон баталгаат болон хадгалах хугацаа дууссан, мөн чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнээр үйлчлэх;

2.7.2. хэрэглэгчийг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, үндэслэлгүй тогтоосон үнэ тариф мөрдөх;

2.7.3. хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулах, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах аюултай бодис, технологийг зөвшөөрөлгүйгээр ашиглах;

2.7.4. техникийн үйлчилгээ, засварт хүлээн авсан гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр солих, бусад байдлаар ашиглах;

2.7.5. зохих журмын дагуу тохирлын үнэлгээнд хамрагдаагүй, эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаа тогтоолгохгүйгээр үйлчилгээ эрхлэх.

Гурав. Ашиглалтын материалаар хангах үйл ажиллагаа

3.1. Ашиглалтын материалаар хангах үйлчилгээнд гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, түүний сэлбэг, гал унтраах бодис болон ашиглалтын бусад материалаар (цаашид “бараа, бүтээгдэхүүн” гэх) хангах зэрэг үйлчилгээ хамаарна.

3.2. Ашиглалтын материалаар хангах байгууллагын үүрэг.

3.2.1. нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгөх ба баталгааг дагалдах хуудсаар баримтжуулна;

3.2.2. баталгаат хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаанаас доошгүй байх бөгөөд баталгаат хугацаанд техникийн бүрэн байдалтай холбоотой үйлчилгээг хариуцна;

3.2.3. хэрэв үйлдвэрлэгч удаан хугацаанд хэрэглэх бараанд баталгаат хугацаа тогтоогоогүй бол барааг үйлчлүүлэгчид нийлүүлсэн өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд барааны чанар, аюулгүй байдлын баталгаа гаргана;

3.2.4. нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэх заавар, хадгалах, ашиглахад дагаж мөрдөх зааварчилгаа болон бусад мэдээллийг хэрэглэгчид үнэн зөв өгөх;

3.2.5. гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ашиглалтын хугацаанд найдвартай ажиллагааг хангах зорилгоор техникийн үйлчилгээг зохион байгуулах, түүнчлэн үйлдвэрлэлийн хугацаанд болон түүнийг үйлдвэрлэлээс хассанаас хойш ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд, хэрэв ийм хугацаа заагаагүй бол худалдаанд нийлүүлснээс хойш 5 хүртэл жилийн хугацаанд холбогдох сэлбэг хэрэгслийг худалдаанд нийлүүлж байх.

3.3. Ашиглалтын материалаар хангах байгууллагад хориглох зүйл.

3.3.1. гарал үүслийн гэрчилгээгүй, үйлдвэрлэгчээс тогтоосон баталгаат болон хадгалах хугацаа дууссан, мөн чанарын шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх;

3.3.2. хууран мэхлэх аргаар бараа, бүтээгдэхүүн борлуулан хэрэглэгчийг хохироох.

3.3.3. зохих журмын дагуу тохирлын үнэлгээнд хамрагдаагүй, эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаа тогтоолгоогүйгээр үйлчилгээ эрхлэх.

Дөрөв. Тоног төхөөрөмж угсрах үйлчилгээ

4.1. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг угсрах үйлчилгээнд тэдгээрийн найдвартай ажиллагаа, түүнтэй нийцсэн бусад үйлчилгээг төлбөртэйгөөр үзүүлэхэд хамаарна.

4.2. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж угсрах үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын үүрэг.

4.2.1. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн угсралт нь БНБД болон стандартын шаардлагад бүрэн нийцсэн байх;

4.2.2. гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг угсарсан, хүлээлгэн өгсөн тухай цахим бүртгэл хөтлөх;

4.2.3. гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг угсарснаас хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;

4.2.4. гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг бүрэн хариуцах;

4.2.5. аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулан мөрдөх;

4.2.6. гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж угсрах үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад хориглох зүйл;

4.2.7. зураг төсөлд тусгагдсан гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжөөс өөр тоног төхөөрөмж угсрах;

4.2.8. гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг гал түймэр унтраахаас бусад зориулалтаар ашиглах.

Тав. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн мэдээллийн сан

5.1. “Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн мэдээллийн сан” нь Онцгой байдлын албаны галын аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн төрөлжсөн бусад сантай холбогдон ажилладаг, мэдээлэл солилцдог байна.

5.2. Мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон зааврыг зохих байгууллагуудтай зөвшилцөн Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага боловсруулан хэрэгжүүлнэ.

5.3. Мэдээллийн санд тохирлын үнэлгээ хийх, ангилал тогтоох, засвар үйлчилгээний болон ашиглалтын бусад мэдээлэл хамаарна.

5.4. Ашиглалтын бусад мэдээлэлд тухайн тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд холбогдсон зам тээврийн осол, гал түймэр, байгалийн гамшиг, техникийн хяналтын үзлэг, даатгал болон марк, зориулалт өөрчилсөн мэдээлэл хамаарна.

5.5. Энэхүү журмын 5.4-т заасан мэдээллийг тухайн асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллагууд тухай бүрд нь оруулах ба тэдгээр мэдээллийн сангуудтай холбогдсон байна.

5.6. Мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлал, түүнийг хөгжүүлэх асуудлыг үйлчилгээний эрх бүхий байгууллага хариуцна.

5.7. Мэдээллийн сангийн засвар үйлчилгээний хэсэгт оруулсан мэдээллийг өөрчлөх эрх зөвхөн мэдээллийн сангийн эрх бүхий тушаалтанд байна.

Зургаа. Бусад

6.1. Гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль” болон холбогдох бусад хууль, эрх зүйн баримт бичгийг мөрдөн шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү зааврыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх нь зөвхөн хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтанд хамаарна.

6.4. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

__oOo__

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 5 дугаар сарын 16 -ны өдрийн 49 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар гал түймрийн аюулын үнэлгээ (цаашид-үнэлгээ гэх) хийх, түүнтэй холбогдсон шийдвэр гаргах, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан үнэлгээний аргачлалаар үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

1.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөл нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.8 дугаар зүйлд заасны дагуу Гал түймрийн аюулын үнэлгээ хийх иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эрх олгох, цуцлах, үнэлгээний тайланд шинжилгээ хийнэ.

1.4. Гал түймрийн аюулын үнэлгээг Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.10-д зааснаар ойлгоно.

1.5. Тухайн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын үнэлгээ хийлгэсэн эсэхэд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын гал түймрийн улсын хяналтын байцаагч хяналт тавина.

Хоёр. Гал түймрийн аюулын үнэлгээ, түүнд тавигдах шаардлага

2.1. Гал түймрийн аюулын үнэлгээг хийх аж ахуйн нэгж, удирдлага, мэргэжилтнүүд нь үнэлгээ хийлгэх аж ахуй нэгж, байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй байна.

2.2. Үнэлгээ хийх эрхийг дор дурдсан чиглэлээр олгоно.

2.2.1. Олон нийтийн барилга байгууламжийн галын аюулыг үнэлэх

2.2.2. Үйлдвэрийн барилга байгууламжийн галын аюулыг үнэлэх

2.3. Гал түймрийн аюулын үнэлгээ хийх эрх авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.8.1-18.1.4-т заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.4. Аюулын үнэлгээ хийх эрх авсан байгууллага, аж ахуй нэгж нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18,5, 18.6-д заагдсаны дагуу үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдал, барилга байгууламжид гал түймрийн аюулын үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.5. Үнэлгээний тайланд 3-аас дээш удаа техникийн болон мэргэжлийн шинжтэй алдаа гаргасан, үнэлгээг тогтоосон нөхцөл болзол, батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгээгүй, шаардлагатай материалыг бүрдүүлээгүй, үнэлгээний утгыг шаардлагатай хэмжээнд тодорхойлоогүй нь үнэлгээний тайлангийн шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд үнэлгээ хийх эрхийг хугацаанаас нь өмнө цуцална.

2.6. Иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлт болон шаардлагатай тохиолдолд гал түймрийн аюулын үнэлгээний тайланг Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж болно.

2.7. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.8 дахь хэсгийн шаардлагаас гадна дараах мэдээллийг хянан үзэж үнэлгээ хийх эрхийн хугацааг сунгах эсэхийг мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтээр шийдвэрлэнэ:

2.7.1. Тухайн аж ахуйн нэгжийн хийж гүйцэтгэсэн гал түймрийн аюулын үнэлгээтэй холбоотойгоор санал, гомдол ирсэн эсэх.

2.7.2. Галын аюулгүй байдлын зөвлөх, мэргэшсэн инженерийн орон тооны ажилтнуудын нийгмийн даатгалтай холбоотой асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн эсэх (харьяалагдах нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт, ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар);

2.7.3. Эрхийн хугацаанд хийсэн үнэлгээний ажлын тайлан, мэдээг мэдээллийн санд тогтмол оруулж, үнэлгээний ажилд мэргэжлийн шинжээчдийг байнга татан оролцуулдаг эсэх;

2.8. Үнэлгээний тайланг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд уг тайланг боловсруулсан аж ахуйн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд үнэлгээ хийлгэсэн байгууллагын удирдлагыг заавал оролцуулна.

2.9. Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн хурлаас 3-оос доошгүй хоногийн өмнө хэлэлцүүлэх тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тус зөвлөлийн гишүүдэд хүргүүлсэн байна.

2.10. Үнэлгээ нь гал түймрийн аюулыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, техник, технологийн шийдлийн зөвлөмжийг агуулсан тайлангаас бүрдэнэ.

Үнэлгээний тайланд дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

2.10.1. Гал түймрийн аюулын шинжилгээ хийхэд ашигласан аргачлал

2.10.2. Тухайн объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэгдсэн байдал

2.10.3. Аюулын үнэлгээний үр дүн

2.10.4. Ашигласан материалын жагсаалт

2.10.5. Аюулын үнэлгээний үр дүн зөвшөөрөгдөх утгаас давсан эсэх, хэрэв давсан бол аюулгүй арга хэмжээг тусгасан дүгнэлт, зөвлөмж

2.11. Галын түймрийн аюулын үнэлгээ хийх явцад тухайн барилга байгууламжид гал түймрийн аюултай нөхцөл байдал үүссэн байна гэж үзвэл шаардлагатай арга хэмжээг авах талаар үнэлгээ хийлгүүлэгч байгууллагад болон тухайн нутаг дэвсгэр хариуцсан гал түймрийн улсын хяналтын байцаагчид албан бичгээр мэдэгдэнэ.

Гурав. Мэдээллийн сан

3.1. Үнэлгээний тайлан мэдээллийг нээлттэй болгох зорилгоор онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага объектын гал түймрийн аюулын үнэлгээний мэдээллийн санг байгуулна. Мэдээллийн сан нь дараах мэдээллийг агуулна:

3.1.1. Үнэлгээтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичиг;

3.1.2. Гал түймрийн аюулын үнэлгээ хийгдсэн байгууллагын бүртгэл;

3.1.3. Тайлангийн дүгнэлт, зөвлөмж түүний мөрөөр авсан арга хэмжээ, биелэлт;

3.1.4. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтын мэдээ, түүний мөрөөр авсан арга хэмжээ, биелэлт.

3.2. Үнэлгээний мэдээллийн сан, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн, багаж хэрэгслийг угсрах, ашиглах, засвар үйлчилгээ хийх зааврын мэдээллүүд нь нэгдсэн мэдээллийн сантай уялддаг байх.

3.3. Гал түймрийн аюулын үнэлгээ хийгч аж ахуй, нэгж, байгууллага нь хийсэн үнэлгээ бүрийн хувийг хадгалж, байгууллагын мэдээллийн сан үүсгэх бөгөөд, үнэлгээний тайлангийн дүгнэлт, өгсөн зөвлөмж, нийт тоог Онцгой байдлын байгууллагад сар бүр ирүүлж нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулна.

3.4. Үнэлгээтэй холбоотой гаргасан маргааныг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

__oOo__